



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 он

ТОВЪЁОГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан /хүснэгтээр/.....
2. Бодлогын баримт бичгийн дэлгэрэнгүй тайлан.....
 - 1.1.1 Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиллуулж, сургалтын чанар хүртээмжийг сайжруулна
 - 1.1.2 Нийгмийн эрсдэлт бүлгийн хүүхэд багачуудыг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр сурган хөгжүүлж, анхан, дунд шатны мэдлэг олгоно.....

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан.....
- 2.2 Төвд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох ажилтанд хариуцуулан үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэж, www.smartcity.mn цахим хуудсыг тогтмол хөтлөн ажиллуулна.....

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

1. "ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ" уриан дор олон улс болон улс нийслэлийн хүрээнд үндэсний бичиг соёл, өв уламжлалыг хүүхэд багачуудад сурталчлан таниулах олон талт ажлуудыг зохион байгуулна.....
2. МХУБТ-ийн нэрэмжит тэмцээн уралдаан, үзэсгэлэнг улс, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулна.....
3. Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулиудын дүрслэх урлаг, техник технологийн багш нартай хамтран ажиллах, туршлага солилцох тэмцээн уралдаан, үзэсгэлэн, өдөрлөг, сургалт зохион байгуулна.....
4. Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаан, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.....
5. Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулна.....
6. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг санаачлан зохион байгуулж, төвийн үйл ажиллагааг сурталчлан өргөжүүлнэ.....
7. "Хүүхдэд ээлтэй Урлан" аяныг үргэлжлүүлж, хүүхэд багачуудын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүлнэ.
8. Гадаад улс орнуудын болон олон улсын байгууллагын дэмжлэгээр төсөл хэрэгжүүлж, сургалтын үйл ажиллагааг сайжруулна.....
9. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослоос хамгаалах зорилгоор холбогдох мэргэжлийн хүмүүсээр сургалт зохион байгуулна.....
10. Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаанд багш, сурагчдыг идэвхтэй хамруулна.....
11. Төвийн багш нарын "УРЛАГ БА УРЛАХУЙ" шилдэг уран бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулна.....

12. Багшийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулна.....
13. Төвийн багш, албан хаагчдын компьютер, гадаад хэлний мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор сургалтад хамруулна.....
14. Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн талаарх ойлголт болон шинээр гарсан хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулна.....
15. Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд болон бусад мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулна.....
16. Багш, албан хаагчид, сурагчдын нийгмийн асуудалд анхаарч эрүүл мэндийн үзлэгт хамруулна.....
17. Бүжгийн сургалт, спорт өдөрлөг, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол зохион байгуулж, бие бялдар эрүүл мэндийг дэмжинэ.....
18. Ажлын байрны болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон цаашдын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгана.....
19. Төрийн албан хаагчдад зориулан Авлигын эсрэг боловсрол олгох сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллана.....
20. Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглаж, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллана.....
21. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглана.....
22. Байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулж, цахим нөхөн бүрдүүлэлтийг тогтмол хийнэ.....
23. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулж, үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллана.....
24. Багш, сурагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай харилцан туршлага солилцоно.....
25. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төвийн үйл ажиллагааг сурталчилж, хүүхэд багачуудад дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн цуврал хичээл бэлтгэж нийтийн хүртээл болгоно.....
26. Төвийн байнгын галерейг шинэчилж төрөлжүүлнэ.....
27. Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд төвийн багш, сурагчдын хамтарсан “УРЛАХУЙН ЕРТӨНЦ” тайлан үзэсгэлэнг зохион байгуулна.....

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....

1. Төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, дугуйлангийн талаарх мэдээ мэдээллийг төвийн вебсайт, Фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллана.....
2. Хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллана.....
3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.....

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

ДҮГНЭЛТ.....

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН /ХҮСНЭГТЭЭР/

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь	Дэлгэрэнгүй тайлбар
				Он	Түвшин				
1	2	3	4	5	6	7	8	9	10
4.5.3 Монголын Хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төвийн салбар дугуйлангуудыг алслагдсан дүүрэг, хороодод ажиллуулах, хувийн хэвшлийн сургалтын төвийн секц, дугуйланг дэмжих замаар хүүхдийн авьяасыг хөгжүүлж, секц дугуйланд хамрагдалтыг 30 хувь нэмэгдүүлнэ.	4.91 Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төвийн салбар дугуйлангуудын чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд дүүрэг, хороод болон олон улсын байгууллагатай хамтран ажиллана.	1.1.1 Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиллуулж, сургалтын чанар хүртээмжийг сайжруулна.	Дугуйланд хамрагдах хүүхдийн тоо	2019	2005	2050	2079	100%	-
5.3.7 Иргэдийн өргөдөл, гомдлыг хороодоор болон хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэддээ ил тод, нээлттэй шийдвэрлэнэ.		Төвд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох ажилтанд хариуцуулан үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэж, www.smartcity.mn цахим хуудсыг тогтмол хөтлөн ажиллуулна		2020	2005	2015	2079	100%	-

Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа:

4.96. Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг өргөжүүлж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1 “Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиллуулж, сургалтын чанар хүртээмжийг сайжруулна.” зорилтын хүрээнд:

2019-2020 оны хичээлийн жилд Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг дараах байдлаар нээн ажиллуулж байна.

- ХУД-ийн 9 дүгээр хороотой хамтран Нийслэлийн 114 дүгээр сургуульд Сүрлэн сүлжмэлийн дугуйлан /28-32 хүүхэд/



- Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад Уран хайчилбарын дугуйлан /26 хүүхэд/



- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт анхан шатны дугуйланд 17-20 хүүхэд тус тус хичээллэж байна. /17-20 хүүхэд/



- БЗД-ийн 16 дугаар хороонд байрлах Өнөр бүл хүүхдийн төвд Хувцас дизайны болон Анхан шатны дугуйлан /56-60 хүүхэд/



- 60 дугаар сургуульд Монгол уран бичлэгийн дугуйлан /35 хүүхэд/



- Сүхбаатар дүүрэг 10-р хороо 100 айл Уран зургийн дугуйлан /9 хүүхэд/
- Сүхбаатар дүүрэг 15-р хороо Уран зургийн дугуйлан /2 хүүхэд/



•

1.1.2 “Нийгмийн эрсдэлт бүлгийн хүүхэд багачуудыг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр сурган хөгжүүлж, анхан, дунд шатны мэдлэг олгоно”- зорилтын хүрээнд:

Засгийн Газрын Хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, Гэр бүл, Залуучууд хөгжлийн газартай хамтран эрсдэлт бүлгийн хүүхэд багачуудад дүрслэх урлаг, гар урлалын чиглэлээр мэдлэг олгох зорилгоор “Би нар” төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

Тус төслийн эхний шат 2020 оны 06 сарын 01-ны өдрийг хүртэл үргэлжлэх бөгөөд эрсдэлт бүлгийн 800 хүүхдийг хамруулах зорилго тавин ажиллаж байна.

- Баянзүрх дүүрэг 111 дүгээр сургуульд Уран зургийн дугуйлан /31 хүүхэд/



- Баянзүрх дүүрэг Хөгжлийн хэлхээ асрамжийн газар Уран зургийн /14 хүүхэд/



- Баянгол дүүрэг 6-р хороо Иргэний танхим Монгол уран бичлэг /38 хүүхэд/



- Баянгол дүүрэг 6-р хороо Уран зургийн дугуйлан /18 хүүхэд/



- Чингэлтэй дүүрэг 16-р хороо Уран зургийн дугуйлан /15 хүүхэд/



Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг хороодын 300 гаруй хүүхдийг төвийн салбар дугуйланд хамруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Манай төв удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэрийг тогтмол үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилт ийн явц	Үнэлгээ	Шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
1.а. Монгол Улсын хууль					
	9, 27.1, 31	Төрийн албаны тухай хууль	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	-
	16.5	Төсвийн тухай хууль	2019 онд нийт 784,979,161.00 төгрөгийн орлогоос 774,512,646.00 төгрөгийн зарцуулалт хийгдэж 10,466,515.00 төгрөгийн үлдэгдэлтэй өглөг авлагагүй ажиллаа.	100%	-
	6, 7	Шилэн дансны тухай хууль	Хуулиар тогтоосон хугацаанд https://shilendans.gov.mn/org/4315 сайтад мэдээллийг тогтмол байршуулж байна.	100%	-
	5	Хөдөлмөрийн тухай хууль	Хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж, ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр ханган ажиллаж байна.	100%	-
	6	Хүүхэд хамгааллын тухай хууль	“Хүүхэд хамгааллын төлөвлөгөө”-г 3 зорилтын хүрээнд 39 ажил төлөвлөн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.	100%	-
	7, 8, 9	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн http://huuhdiinurlan.ub.gov.mn/ сайт, фэйсбүүк пейж хуудас болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100%	-
	7, 12, 13, 14, 15, 16	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох х тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж сар, улирал, бүтэн хагас	100%	

		өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	жилээр тайлагнан байна.		
1.6. Улсын их хурлын тогтоол					
51	1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016_51	Нийслэлийн Засаг Даргын 2018.03.23-ны өдрийн А/237 дугаар захирамжаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган төлөвлөгөөг боловсруулж, мөрдөн ажиллаа. Үүнд: 1. Төвийн багш, албан хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно. 2. Төвийн багш, албан хаагчдад авлига, ашиг сонирхлын талаар анхан шатны мэдлэг олгох “Авлигын тухай ойлголт” сургалтыг зохион байгууллаа. 3. Авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах утсыг тогтмол ажиллуулж байна. Ямар нэгэн мэдээлэл ирээгүй болно. 4. Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг төвийн цахим хуудас болон фэйсбүүк хуудаст тогтмол мэдээлж байна. 5. http://shilendans.gov.mn/org/4315 сайтад байгууллагын төсөв, гүйцэтгэлийн мэдээг тогтмол оруулж байна.	100%	
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
1.е. Засгийн газрын тогтоол					
57	1.1	Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмыг шинэчлэн батлах тухай 2017-02-15 Дугаар 2017_57	Тус жилд манай байгууллага гадаад улсын адил түвшний байгууллага болон олон улсын байгууллагатай өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ байгуулаагүй болно.	100%	-
32	2.2, 2.3	2019 оныг “Иргэдийн оролцоотой- Хөгжлийн жил” болгон зарлах тухай	Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн хүрээнд 3 зорилтоор 10 ажил төлөвлөн биелэлийг ханган ажиллаа. -	100%	-

		2019-01-02 Дугаар А/01			
258	1.2, 1.3, 1.7, 1.8, 1.9, 1.10	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, иргэдийг ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш, зөв шударга харьцан ажиллаж байна. 1.3. Ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор төвийн багш, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлууллаа. 1.7. Ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон заалтыг байгууллагын дотоод журамдаа тусган биелэлтэнд хяналт тавьж ажиллаж байна. 1.8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төвийн гадна талбайд камер суурилууллаа. 1.9. Эерэг уур амьсгалтай ажиллах орчинг бүрдүүлэх зорилгоор Талархлын сар, Бидний урлан аянг зохион байгууллаа.	100%	-
1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
16	ХҮ.2.	2018 оны 4 сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 Дугаар 2018_16	Төвийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж нийт хамт олны хурлаар хэлэлцэж баталлаа. Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг хяналтын камер, жижүүрийн бүртгэлээр баталгаажуулан хяналт тавьж байна. Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	-
21	XXIX. 2.4.	2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2019-05-16 Дугаар 2018_21	Хөдөлмөрийн зөрчил гаргасан ажилтан Т.Ганхуяг, Хүний нөөцийн ажилтан Л.Атар нарт Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг үндэслэн сахилгын шийтгэл ногдууллаа.	100%	-
36	XIY.1.	2018 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2018-08-29	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуульд заасан хугацааны дотор хариу өгч шийдвэрлэж байна.	100%	-

		Дугаар 2018_36			
1.3. Засгийн газрын албан даалгавар					
01	1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 Дугаар 2017_01	• <i>Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх хүрээнд:</i> Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хууль дээдлэх зарчим баримтлан мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн ажиллаж байна. • <i>Авлигын хяналтыг сайжруулах хүрээнд:</i> “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, мөрдөн ажиллаж байна. • <i>Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх хүрээнд:</i> Төвд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох ажилтанд хариуцуулан үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. • <i>Төрийн албаны үр ашгийг сайжруулах хүрээнд:</i> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллаж байна. • <i>Бодлогын тогтвортой байдлыг хангах хүрээнд:</i> Төрийн бодлогыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	-
1.и. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол					
119	1.2.2, 1.3.1, 1.3.2, 1.3.3, 1.3.4, 1.3.5	“Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	• Хамтын ажиллагааны хүрээнд “Хурд Интернэшнл” ХХК-аар төвийн автомашины зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний 3 тусгай зогсоолыг шинээр бий болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг ханган ажиллаж байна.	100%	-

		2018-07-09 2018_119	• Мөн хурд сааруулагч болон явган хүний гарцыг зам талбайн стандартад нийцүүлэн шинэчлэн тохижуулж, хүүхдийн аюулгүй байдалд онцгой анхааран ажиллаж байна. • Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Угтах үдэх үйлчилгээний журам”-ыг шинэчлэн баталж, бага насны хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчийн гарт хүлээлгэн өгөх, авах зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. • Цаг үеийн шинжтэй мэдээ мэдээлэл болон мэргэжлийн байгууллагын тавьсан шаардлага, сануулгыг суралцагч хүүхдүүдэд тухай бүр уламжилж, мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна.	100%	
70	1.1.6, 1.3.1, 1.3.2	“Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зарим арга хэмжээний тухай” 2018-05-23 2018_70	Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн автомашины зогсоолын 15 зогсоол буюу 39.4 хувьд төвийн багш, албан хаагчдын автомашиныг байршуулж, үлдсэн 60.5 хувийг суралцагч хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдын автомашиныг байршуулан ажиллаж байна. Төвийн автомашины зогсоолыг ажлын болон ажлын бус өдрүүдэд үнэ төлбөргүй ашиглуулдаг болно.	100%	-
1.ы Нийслэлийн Засаг даргын захирамж					
		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газрууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай. 2019-01-03 А/09	Тус төв нь 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгуулж “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан.	100%	
		Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцуулах	Тус төвийн Гамшгаас хамгаалах штаб НЗД-ын А/88, А/243 тоот захирамж болон НЗДТГ-ын 03/1089, 03/1531 албан тоотын дагуу 4-р сарын 22-нд	100%	

		тухай 2019-03-26 А/243	нийтийн цугларах талбайд нийт 57 хүн сургуулилтад оролцлоо. 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өглөөний 07:00-09:30 цагийн хооронд зохион байгуулсан гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн бүх албан хаагчид бүрэн хамрагдаж ажиллаа.		
		Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай 2019-04-11 А/285	МХУБТөв 2019 оны 4 сарын 20-ны өдрийн 11:00-13:30 цагийн хугацаанд "Их цэвэрлэгээ 90 минут" арга хэмжээний хүрээнд Туул, Дунд гол Алтай хотхоны Космо дэлгүүрээс 370 метр газарт цэвэрлэгээнд 30 ажилтан албан хаагч, байгууллага орчны 50метр нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн сандал хайс хашаа, хогийн сав, байгууллагын хаалга шат хаягын байгууламжийг угааж цэвэрлэн, цэвэрлэгээнд 14 үйлчилгээний ажилчид хамрагдлаа. Тус захирамжийн хэрэгжилтийг хангаж нийт 44 ажилтан "Их цэвэрлэгээ 90 минут" хамрагдлаа.	100%	
		Нийгмийн хэв журам хангах зарим арга хэмжээний тухай. 2019-04-19 А/337 Авто зам замын байгууламж түр хаах тухай. 20 А/338 Ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай. 2019-04-19 А/339	2019 оны 04 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль"-ийн хүрээнд 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 07:00 цагаас 09:30 цагийн хооронд авто замын хөдөлгөөн хааж зам хаасантай холбогдуулан ажил эхлэх цагийн хуваарь 10:00 цагаас 19:00 цаг болгох талаар төвийн нийт багш ажилчдад мэдээллэж биелэлтийг хангаж ажиллаа.	100%	
		Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай 2019-05-08 А/417	Захирамжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа.	100%	
		Журам батлах тухай 2015-07-29 А/633	Нийслэлийн Архивын газраас ирүүлсэн 2019 оны 05 дугаар сарын 15-нд ирүүлсэн 02/244 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж албан хаагчдын ажлын байр өөрчлөгдсөн, солигдсон, гарсан тохиолдолд А/633 дугаар захирамжаар ажил хүлээлцэж, ажил	100%	

			хүлээлцэх ажлын хэсэгт архив, бичиг хэргийн ажилтныг оролцуулан хүлээлцэж байна.		
		Төлөвлөгөө батлах тухай 2019-05-20 А/475	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хэмжээнд тус төвд хамаарагдах чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.		
		Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг зохион байгуулах тухай 2019-05-30 А/518	Захирамжийн дагуу төвийн захирлын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/07 тоот тушаалаар Дэд захирлаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулж 4 үндсэн чиглэлд 75 үзүүлэлттэй төлөвлөгөө боловсруулж батлуулан улсын үзлэгт бэлтгэн шалгуулж 88,6% В үнэлгээ аван ажиллаа.	100%	
		Журам батлах тухай 2019-07-08 А/682	Нийслэлийн засаг даргын тамгын газрын явуулын ажлын байрны үйл ажиллагааны журмыг төвийн багш ажилчдад танилцуулж шаардлагатай мэдээллээр ханган ажиллаа	100%	
		Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2019-06-05 Дугаар А/558	2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх батлах тухай захирамжаар Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн захирал бүрэлдэхүүнд нэмэгдэж хүүхдийн эрхийг хангах ажлуудад биечлэн оролцож НЗДТГ болон Нийслэлийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газартай хамтран “Би нар” төслийн хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	
		“Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт”-ийн улсын үзлэгийн дүнгийн тухай 2019-12-20 Дугаар А/1340	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр “В” үнэлгээ авч зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	

2.2 “Иргэдийн өргөдөл, гомдлыг хороодоор болон хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэддээ ил тод, нээлттэй шийдвэрлэнэ” заалтын хүрээнд:

2019 онд ирсэн 14 хүсэлтийг ub.epr.mn-д бүртгэн цаг тухайд нь хариу өгч 100% шийдвэрлэж ажиллаа.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРЭГ

3.1.1. “2.1 Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ” заалтын хүрээнд:

2.1.2. “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” уриан дор олон улс болон улс нийслэлийн хүрээнд үндэсний өв уламжлалыг хүүхэд багачуудад сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулна.

❖ “МӨНХ ТЭНГЭРИЙН БИЧИГ” Олон улсын хүүхдийн Монгол уран бичлэгийн үзэсгэлэн Их эзэн Чингис хааны мэндэлсэн Монгол бахархлын өдөрт зориулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд тус үзэсгэлэнг амжилттай зохион байгууллаа. “Мөнх тэнгэрийн бичиг” үзэсгэлэнгийн нээлтэд Ерөнхийлөгч Х.Баттулга оролцон үг хэлж, шалгарсан шилдэг бүтээлийн эздэд шагнал гардуулсан. Бага /6-7/, дунд /8-9/, ахлах /10-12/ гэсэн 3 ангилалаар хүүхдүүд бүтээлээрээ оролцсон. Ангилал тус бүрд Тэргүүн, Дэд, Гутгаар, Тусгай байр /2/-ын 5 бүтээл, нийт 15 бүтээл шалгаруулсан.



Үзэсгэлэнд хөдөө орон нутаг, Нийслэлийн нийт 310 гаруй хүүхдийн 220-иод бүтээл тавигдсан. Үзэсгэлэн Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн Орд арт галлерейд 2019.11.25-12.09 хүртэл дэлгэгдсэн. Нийслэлийн сургуулийн сурагчид хамт олноороо ирж үзэсгэлэнг үзэж сонирхсон.

❖ Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвөөс санаачлан “ТУСГААР ТОГТНОЛЫН ҮНЭ ЦЭН” хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдаан

Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээл дор “Эх орончдын өдөр”-ийг тохиолдуулан хүүхэд багачуудад үндэсний эрх чөлөө, эв нэгдэл, тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгуулах, Монгол Улсын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, түүхэн үйл явдлыг олон нийтэд сурталчлан таниулах, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор “ТУСГААР ТОГТНОЛЫН ҮНЭ ЦЭН” хүүхдийн уран бүтээлийн уралдаан, үзэсгэлэнг зохион байгууллаа. Тус наадамд Завхан, Өвөрхангай, Баян-Өлгий, Өмнөговь, Дорнод, Булган, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Архангай, Сүхбаатар, Хөвсгөл, Увс, Орхон, Хэнтий зэрэг 16 аймаг, Нийслэлийн 8 дүүрэг, мөн Өнөр бүл хүүхдийн төв, Чингэлтэй дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Гэгээлэн төв” зэрэг нийт 740 хүүхэд бүтээлээрээ оролцож, шилдэг 21 хүүхдийг шагнаж урамшууллаа.



❖ “БИЧИГ СОЁЛ -2019” Монгол уран бичлэгийн үзэсгэлэн

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Соёл Урлагийн газар, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Бичиг Соёл боловсролын төвийн хамтран зохион байгуулсан “БИЧИГ СОЁЛ” уран бүтээлийн үзэсгэлэнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Монгол уран бичлэгийн ангийн 35 сурагч амжилттай оролцлоо.


“БИЧИГ СОЁЛ-2019” Монгол уран бичлэгийн үзэсгэлэнгийн хүрээнд Нийслэлийн Ерөнхий Боловсролын сурагчдын дунд зохион байгуулсан “БИЙРИЙН ЭРДЭМ” уралдаанд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Монгол уран бичлэгийн ангийн 3 сурагч шагналт байр эзэллээ.



❖ “НЭГ ЕРТӨНЦ” яруу найраг, Монгол уран бичлэгийн үзэсгэлэн

Дэлхийн яруу найрагчдын өдрийг тохиолдуулан Монголын Зохиолчдын Эвлэлтэй хамтран үгээр урлахуй, бийрээр урлахуйг нэгэн дор цогцлоосон "Нэг ертөнц" яруу найраг, Монгол уран бичлэгийн үзэсгэлэнг зохион байгууллаа. Тус үзэсгэлэнгийн зорилго нь Монгол бичиг соёлын гайхамшгийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, Монгол өв соёлоороо бахархах, хүүхэд залуучуудад яруу найраг уран зохиолын сайхныг мэдрүүлэх, таниулахад оршино.

Төвийн уран бичлэгийн дугуйлангийн 22 сурагч, 42 нэрт яруу найрагчийн бүтээлийг Монгол уран бичлэгээр сийрүүлж, орчин үеийн уран бичлэгийн сэтгэлгээ болон чиг хандлагыг яруу найргийн гайхамшгийн хамт илэрхийлэн олны хүртээл болголоо.



❖ Монгол Уран бичлэгийн үзэсгэлэн

Монгол улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулан Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн сурагчид, ӨМӨЗО-ны Ордос хот, Хөх хот, Эрээн хот, Шилийн гол аймгийн хүүхдүүдтэй хамтарсан Монгол Уран бичлэгийн үзэсгэлэнг “Орд” Арт галерейд зохион байгуулсан. Тус үзэсгэлэнд ӨМӨЗО-ноос 52 сурагч эцэг эх, багш нарын хамт хүрэлцэн ирж оролцсон.

Үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээнд Олон улсын Монгол уран бичлэгийн холбооны удирдах зөвлөлийн дарга Р.Отгонбаатар, Олон улсын Монгол уран бичлэгийн холбооны гүйцэтгэх захирал гүйцэтгэх А.Далангурав, Олон улсын Монгол уран бичлэгийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Б.Мөнгөнхишиг, Өвөр Монголын Монгол уран бичлэгийн холбооны дэд тэргүүлэгч Н.Дэгжилт, Эрээн хотын Монгол уран бичлэгийн холбооны тэргүүн Сайнцогт, Шилийн гол аймгийн Шулуун хөвөөт цагаан хошууны монгол уран бичлэгийн холбооны тэргүүн Содцогт нар хүрэлцэн ирж оролцсон.



“2.1.3 “МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН НЭРЭМЖИТ” уран зураг, гар урлал, монгол уран бичлэг, техник технологийн тэмцээн уралдаан үзэсгэлэнг улс, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулна.

❖ УДИРДЛАГАТАЙ АВТО ЗАГВАРЫН” анхдугаар тэмцээн

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн авто загварын дугуйлангийн нэрэмжит өөрсдийн зохион бүтээсэн Радио удирдлагатай бартаат замын авто загварын тэмцээнийг анх удаа 2019 оны 05 дугаар сарын 04-нд зохион байгууллаа.

Тус уралдаанд авто загварын дугуйлангийн 12 сурагч оролцсоноос “УАЗ-469”, “Камаз-дакар”, “Багги”, “Татра” зэрэг дуураймал загварын бүтээлүүд шилдгээр шалгарлаа. Уралдааны шүүгчээр Монголын хүүхдийн Урлан Бүтээх төвийн авто загварын дугуйлангийн багш Н.Хэнмэдэх, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн оюутан Б.Төгс-Эрдэнэ нар ажиллаа.



“2.2. Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлнэ.

2.2.1 Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулиудын дүрслэх урлаг, техник технологийн багш нартай ажиллах, туршлага солилцох замаар тэмцээн уралдаан, үзэсгэлэн, өдөрлөг, сургалт зохион байгуулна.

❖ **“ШИНЭЛЭГ САНАА -2019” Нийслэлийн дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын хоёрдугаар наадам**

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв, Нийслэлийн Боловсролын газар хамтран хоёр дахь жилдээ Нийслэлийн Ерөнхий Боловсролын Сургуулийн дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын “ШИНЭЛЭГ САНАА-2019” уран бүтээлийн наадмыг амжилттай зохион байгууллаа. Тус наадмын зорилго нь Ерөнхий Боловсролын Сургуулийн дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын авьяас чадвар, уран бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, дэмжих, харилцан туршлага солилцоход оршино. “Шинэлэг санаа-2019” хоёрдугаар наадамд нийслэлийн 100 гаруй сургуулийн багш нар уран зураг, медиа урлаг, уран баримал, ардын урлаг, чимэглэх урлаг, орчин үеийн урлаг гэсэн 6 төрлийн 120 бүтээлээр оролцож, шилдэг 5 багшийг шагналаа.



“2.3 Өөрийн орны болон гадаад улс орнуудын төрийн, төрийн бус байгууллага, иргэнтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамтарч ажиллана” заалтын хүрээнд:

2.3.1 Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаан, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

❖ **“Нөхөрлөл” уран зургийн үзэсгэлэн**

Монгол улс БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд 2 улсын хүүхдүүдийн хамтарсан “Нөхөрлөл” уран зургийн үзэсгэлэнг зохион байгууллаа. Тус үзэсгэлэнд Өвөр Монголын “Заяа-хан” хүүхдийн зургийн дугуйлан болон Монголын Хүүхдийн Урлаг бүтээх төвийн нийт 100 гаруй авьяаслаг хүүхэд багачуудын уран бүтээл дэлгэгдэж нээлтэнд Өвөр Монголын Боловсролын товчоо, Өвөр Монголын Ардын засгийн Газрын хэвлэл мэдээллийн алба, Монгол Улсаас Хөх хотод суугаа Ерөнхий Консулын газар, Өвөр Монгол дахь Монгол Улсын Иргэдийн нийгэмлэг зэрэг байгууллагуудаас төлөөлөгчид оролцож шилдэг шалгарсан хүүхдүүдэд шагнал гардууллаа.



❖ **“Байгал Говь” үзэсгэлэн**

ОХУ-ын Иркутск хотын тусгай хэрэгцээт 20-р сургууль, Монголын Улсын тусгай хэрэгцээт 25-р сургууль, Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв хамтран Орос, Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн авьяас чадвар, бүтээлч сэтгэхүйг дэмжих, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Байгал Говь” үзэсгэлэнг зохион байгууллаа.

Тус үзэсгэлэнд ОХУ-ын Иркутск хотын тусгай хэрэгцээт 20-р сургууль, Монголын Улсын тусгай хэрэгцээт 25-р сургууль, Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн сурагчдын нийт 120 гаруй бүтээл Орд галерейд дэлгэгдэв.



❖ "ТОРГОНЫ ЗАМ ОЛОН УЛСЫН ЗАГВАРЫН ДОЛОО ХОНОГ- ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮД" үзэсгэлэн

Хятадын үндэсний урлагийн сангаас зохион байгуулагдаж байгаа "Торгоны Зам Олон Улсын загварын долоо хоног - Шилдэг бүтээлүүд" Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Орд арт галерейд амжилттай зохион байгуулагдлаа. "Торгоны Зам Олон Улсын загварын долоо хоног-Шилдэг бүтээлүүд" үзэсгэлэн нь хилийн чанад дахь явуулын үзэсгэлэн юм.

Энэхүү үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээнд "Торгоны Зам Олон Улсын загварын долоо хоног" зохион байгуулах хорооны дарга ВАН ХАО ТИАН, Хятадын ЭСЯ-ны зөвлөх Ли Яао, Хятадын Соёлын төвийн захирал Хас, Монгол Хятадын Аялал жуулчлалын найрамдалын нийгэмлэгийн дарга Жао Рунлин нар нээж үг хэллээ.



- ❖ Боловсрол Сургалтын Хүрээлэн ТББ нь Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв болон Туркийн Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Мөхиттин Ахмет Язал эхнэр Кадире Зенеф Саяим нарын дэмжлэгтэйгээр уран зургийн үзэсгэлэн зохион байгууллаа.

Тус үзэсгэлэн нь зураг, уран зохиолыг сурталчлан таниулах явдал бөгөөд ЕБС-ийн 2, 3-р сургууль, Амгалан Цогцолбор, Монгол Улсын Консерватори мөн олон улсын англи сургуулийн нийт 130 гаруй сурагч идэвхтэй оролцлоо.



- ❖ **“МОНГОЛ ХЯТАД НӨХӨРЛӨЛ” уран зургийн уралдаан**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад Суугаа Элчин Сайдын Яам, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд “Монгол Хятад нөхөрлөл” уран зургийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд төвийн 500 сурагч оролцсоноос 1 хүүхэд шилдгээр шалгарч БНХАУ-ын Шанхай хотын Олон улсын хүүхдийн арга хэмжээнд Монгол Улсаа төлөөлж амжилттай оролцлоо.



❖ “БИДНИЙ НАЙРАМДАЛ” Олон улсын хүүхдийн гар урлал, уран зургийн уралдаан

Монгол улсаас БНХАУ-ын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газар, Өвөр Монгол дахь Монгол иргэдийн нийгэмлэг, ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын хэвлэл мэдээллийн алба, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан “Бидний найрамдал” сэдэвт гар урлал, уран зургийн уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдааны зорилго нь Монгол Улс, БНХАУ-ын дипломат харилцаа тогтоосны 70 жил, Монгол, Хятад улсын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг сурталчлан таниулах, хүүхэд багачуудын дотоод ертөнц, хүсэл мөрөөдлөө дүрслэн зурах, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй бүтээлч байдлаар илэрхийлж, авьяас сонирхлыг нээхэд оршино.

Тус уралдаанд 1150 хүүхэд бүтээлээрээ оролцсоноос Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 6 хүүхэд, 1 багш шагналт байранд шалгарлаа.



2.3.2. Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулна.

❖ **“МОНГОЛ СОЛОНГОСЫН НӨХӨРЛӨЛ” гар урлал, уран зургийн уралдаан**

БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран жил бүр хүүхдийн уран зураг, гар урлалын уралдааныг уламжлал болгон зохион байгуулдаг билээ. Энэ удаагийн гар урлал, уран зургийн уралдаан 5 дахь жилдээ “Монгол Солонгосын нөхөрлөл” сэдэвтэй зохион байгуулж шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа боллоо.

Үзэсгэлэнгийн нээлтийн үйл ажиллагаанд урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын хэргийг түр хамаарагч Жон Гван Шиг, Элчин сайдын яамны 1-р нарийн бичгийн дарга Пак Ын Жон, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн удирдлагууд болон бусад хүндэт зочид төлөөлөгчид оролцов.





❖ “БАЯРЛАЛАА ТУРК ОРОН” хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн

Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /TIKA/-ийн буцалтгүй тусламжаар Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч, Бүгд Найрамдах Турк улсад чин сэтгэлийн талархлаа илэрхийлэх, цаашдын хамтын ажиллагаа, гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор “БАЯРЛАЛАА ТУРК ОРОН” хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэнг 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Тус үзэсгэлэнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн дугуйлангийн сурагчид уран зураг, гар урлал, технологийн 162 бүтээлээр оролцлоо.



❖ Монгол Энэтхэг улсын “ӨНГӨРСӨН-ОДОО-ИРДЭЭҮЙ”

БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Улаанбаатар хот дахь Энэтхэгийн соёлын төвтэй хамтран Монгол улсын Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн уран зураг, гар урлалын наадмыг зохион байгуулав.

Монгол Энэтхэг улсын “ӨНГӨРСӨН-ОДОО-ИРДЭЭҮЙ” сэдэвтэй гар урлал, уран зургийн наадам 5 дахь жилдээ зохион байгуулагдаж шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа боллоо.

Үзэсгэлэнгийн нээлтийн үйл ажиллагаанд урилгаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингх, Энэтхэг улсын ЭСЯ-ны 1-р нарийн бичгийн дарга О.Р.Мийна, ЭСЯ-ны Соёлын аташи Неги, Улаанбаатар хот дахь Энэтхэгийн соёлын төвийн тэргүүн Л.Саянаа, УИХ-ын гишүүн Ундармаа, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн удирдлагууд болон бусад хүндэт зочид төлөөлөгчид оролцов.



❖ "ГОО ИВЭЭЛ" хувцас загварын чимэглэл зургийн үзэсгэлэн



МОНГОЛЫН
САНХҮЙ АЖ АХУЙН
ТӨСӨЛ

Хүснэгт 1

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 2

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 3

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 4

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 5

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 6

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 7

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 8

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 9

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 10

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 11

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 12

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 13

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 14

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 15

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 16

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 17

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 18

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 19

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 20

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 21

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 22

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 23

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 24

БҮТЭЭЛЭЛТ

БҮТЭЭЛИЙН СЭДЭГ



Хүснэгт 25

БҮТЭЭЛЭЛТ



❖ “УРАН БАРИМАЛ- 2019” үзэсгэлэн, уралдаан

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв, Соёл Урлагийн Их Сургуулийн Дүрслэх, Дизайн Урлагийн Сургуулийн уран баримлын тэнхимтэй хамтран “Уран баримал-2019” үзэсгэлэн, уралдааныг зохион байгууллаа. Тус үзэсгэлэн уралдаанд “Модерн болон бодит” арт чиглэлээр бүтээсэн уран баримал, фото зураг, хар зургийн 30 гаруй уран бүтээлчдийн 65 бүтээл оролцлоо. Авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээ, уран сэтгэмжээрээ бусдыгаа манлайлсан шилдэг уран бүтээлч, сурагчдыг тодруулж, Дүрслэх, дизайн урлагийн сургуульд шалгалтгүйгээр элсэн суралцах эрхээр шагнав.





❖ “ДЭЭРЭЛХЭЛ МИНИЙ БОДЛООР” сурагчдын гар зургийн үзэсгэлэн

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв ТББ “Оюу толгой” ХХК, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран “Дээрэлхэлтийн эсрэг хамтдаа” аяны хүрээнд “Дээрэлхэлт миний бодлоор” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд ирүүлсэн 200 бүтээлээс шилдэг 10 бүтээлийг шалгаруулав.



Сурагчид бүтээлээрээ дамжуулан үе тэнгийнхэн, насанд хүрэгчдэд хандан үе тэнгийн дарамт, дээрэлхлийг зогсооход хүн бүрийн оролцоо чухал тул хажуугаар нь чимээгүй өнгөрч болохгүй гэх санааг хүргэхийг зорьсон.



❖ “ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ДАВТАН СУРГАЛТ СЭРГЭЭН ЗАСЛЫН ТӨВ”-д зохион байгуулсан сурагчдын уран зургийн үзэсгэлэн

Эх орон, байгаль орчин, ард иргэдийнхээ аюулгүй байдлын төлөө цаг наргүй ажилладаг Онцгой Байдлын Ерөнхий газрын харьяа Давтан сургалт Сэргээн заслын төвийн хүндэт албан хаагчдад урам зориг, баяр баясгалан бэлэглэх зорилгоор Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн сурагчид уран зургийн үзэсгэлэн зохион байгууллаа. Тус төвд дугуйлангийн сурагчдын шилдэг 30 бүтээл дэлгэгдлээ.



❖ **“ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭН БА ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА”
хүүхдийн уран зургийн үзэсгэлэн**

Монгол Улсын Их Хурлын Гишүүн, Шадар Сайд Ө.Энхтүвшиний ивээл дор зохион байгуулагдсан “Гэр Бүлийн Үнэ Цэн Ба Эцэг Эхийн Үүрэг Хариуцлага” зөвлөгөөнд Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн дугуйлангийн сурагчдын уран зургийн үзэсгэлэн гаргалаа.



❖ **“ХӨДӨЛМӨР НИЙГЭМ ХАМГААЛЛЫН САЛБАРЫН НЭЭЛЛТЭЙ” хаалганы өдөрлөг**


Хөдөлмөр нийгмийн хамгааллын цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх зорилготой “Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын салбарын нээлттэй хаалганы өдөрлөг”-т Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн багш, албан хаагчид хамтран оролцлоо.

Тус өдөрлөгт төвийн дугуйлангийн сурагчдын уран зураг, хүүхэлдэй бэлэг дурсгал, сүрлэн наамал, уран сийлбэрийн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, Монгол уран бичлэгийн дугуйлангийн сурагчид уран бичлэгийн үзүүлэнгээр олон нийтэд бэлэг барив.



❖ **“ГЭР БҮЛ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЬЕ” хүүхдийн уран зургийн үзэсгэлэн**

Монгол Улсын Их Хурлын Дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор зохион байгуулагдсан “Гэр Бүл, Хүүхдэд Ээлтэй Эрх Зүйн Орчныг Бүрдүүлбэ” зөвлөгөөнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 9 багш, албан хаагч оролцож, дугуйлангийн 40 сурагч уран зургийн бүтээл дэлгэж, үзэсгэлэнгээ гаргалаа.



❖ **“ЗӨВ ТУСГАЛ ХӨДӨЛГӨӨН НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” багш, сурагчдын гар урлалын үзэснэлэн**

Нийслэлийн Цагдаагийн Газраас Нийслэлийн Ерөнхий Боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан “ЗӨВ ТУСГАЛ” хөдөлгөөн “Нээлттэй хаалганы өдөрлөгт Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв багш сурагчдын гар урлалын бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж оролцлоо.





❖ **“ХҮҮХДЭЭ СОНСОХ ӨДӨР” хүүхдийн гар зургийн үзэсгэлэн**

Хүүхэд үзэл бодол, дуу хоолойгоо илэрхийлэх, мэдээлэл авах, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх боломжийг хангах зорилгоор “ХҮҮХДЭЭ СОНСОХ ӨДӨР”-өөр “Хүүхэд бидний аюулгүй орчин” сэдэвт хэлэлцүүлэгт Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 3 багш, албан хаагч оролцлоо. Тус өдөр төвийн дугуйлангийн сурагчдын хүүхдийн ертөнц, үзэл бодлыг илтгэн харуулсан уран зургийн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа.



❖ **“ASIA FOLK- 2019” “АЗИЙН АРДЫН УРЛАГИЙН ИХ НААДАМ” хүүхэлдэй урлалын үзэсгэлэн**

Соёл урлагийн газраас зохион байгуулсан орон орны авьяастнууд хуран чуулсан “ASIA FOLK-2019” “Азийн Ардын Урлагийн их наадам”-д Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв хүүхэлдэй урлалын бүтээлээр үзэсгэлэн гаргалаа.



“2.4. Сургалт явуулах орчин бүрдсэн, сургалтын хэрэглэгдэхүүн бүрэн анги танхимд сургалт явуулна” заалтын хүрээнд:

2.4.1. “Хүүхдэд ээлтэй Урлан” аяныг үргэлжлүүлж, хүүхэд багачуудын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүлнэ.

❖ “МАРГАД-ЭРДЭНЭ МИНИЙ ЭРДЭНЭ” “MERAKI” уран зургийн үзэсгэлэн

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв, Улаанбаатар Элит Олон Улсын дунд сургууль хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд Э.Маргад-Эрдэнэ Миний Эрдэнэ” аянд нэгдэн, “MERAKI” хүүхдийн уран зургийн үзэсгэлэнг 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Орд” арт галерейд зохион байгууллаа. Тус үзэсгэлэнгийн зорилго нь хүмүүнлэгийн сайн үйлсийн төлөө Э.МАРГАД-ЭРДЭНЭ хүүд туслах, төр, төрийн бус байгууллага, иргэд, хүүхэд залуучуудад энэрэнгүй үзэл төлөвшүүлэх, бусдад сайнаар үлгэрлэх, дэмжих, тэднийг оролцоог нэмэгдүүлэхэд оршино.



❖ “МОНГОЛ ХҮҮХДҮҮД” баярын арга хэмжээ

Хүүхдийн баярыг тохиолдуулан Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар хамтран зохион байгуулсан “МОНГОЛ ХҮҮХДҮҮД” баярын арга хэмжээ Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн хамт олон идэвх санаачилгатай, амжилттай оролцлоо.

Тус өдөрлөгт төвийн суралцагч хүүхдүүдийн шилдэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, уран зураг, уран бичлэгийн дугуйлангийн сурагчид боди арт болон уран бичлэг хийж сонирхуулан хүүхэд багачуудаа баярлууллаа.



❖ **МИНИЙ МӨРӨӨДӨЛ” урлагийн боловсролын өдөрлөг**



Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан Монголын Урлагийн Зөвлөл, Хас банкттай хамтран 3-14 насны хүүхэд багачуудын дунд “МИНИЙ МӨРӨӨДӨЛ” урлагийн боловсролын өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн зорилго нь хүн бүр мөрөөдөлтэй, хүсэл эрмэлзэлтэй бол амжилтад хүрэх боломжтой гэдгийг ойлгуулах, хүүхдэд урлагаар дамжуулан бүтээлч сэтгэлгээ, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгох, тэдэнд урам зориг өгөх, эцэг эхчүүд хүүхдийнхээ хүсэл мөрөөдлийг дэмжихийг уриалахад оршино.

Өдөрлөгийн хүрээнд мэргэжлийн уран бүтээлчидтэй хамтран “МӨРӨӨДӨЛД ХҮРЭХ ЗАМ” сургалт, “Миний Мөрөөдөл” сэдэвт хүүхдийн уран зургийн уралдааныг тус тус зохион байгуулж, нийт 130 хүүхдийг хамрууллаа.



❖ **“ӨГӨӨМӨР ӨДӨР-2019” өдөрлөг**

Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, хэрэглээний хандлагыг өөрчлөх зорилгоор “Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе” уриан дор хуучин эд зүйлсээ худалдах, солилцох, үнэгүй өгөх өдөрлөг 2019 оны 06 дугаар сарын 09-ний Бямба гаригт Сүхбаатар дүүрэгт зохион байгуулагдлаа. Манай хамт олон зөөлөн тоглоом, цамц өмд, пүүз сандаал, цүнх, ороолт, пальто, гоёл зүүлт, хэвлэгч машин, ном зэрэг 130 ширхэг эд зүйлсийг хүлээлгэн өгч идэвх санаачилгатай оролцлоо




❖ **“МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ МИНИЙ ИРЭЭДҮЙ” хүүхдийн гар зургийн уралдаан, үзэсгэлэн**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан "Монголын Ирээдүй-Миний Ирээдүй" хүүхдийн гар зургийн уралдаанд 1600 хүүхэд оролцсоноос Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвөөс 11 хүүхэд шилдгээр шалгарч, шагнал хүртлээ.





❖ **Гадна талбайн цэцэрлэгжүүлэлт**


Төвийн албан хаагчид гадна талбайн өнгө үзэмжийг сайжруулан цэцгийн мандал тарьж, их цэвэрлэгээ хийлээ.



- ❖ Төвийн дотоод өнгө үзэмжийг сайжруулж 1 дүгээр давхарын засварын ажлыг дотоод нөөц бололцоогоо ашиглан хийлээ.




- ❖ Төвийн гадна талбайд “Гудамжны номын сан” байгуулж иргэд олон нийтэд нээлттэй үйлчилж ном унших, солилцох ажлыг зохион байгууллаа.



- ❖ Худалдаа Хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Хүүхдийн номын сан”-г шинээр байгууллаа.



- ❖ “Дүрслэх урлаг ба гар урлал” анхан, дунд шатны сурах бичгийг шинээр эмхлэн хэвлүүлж урлан бүтээх хүсэл эрмэлзлэл дүүрэн дугуйлангийн сурагчиддаа бэлэг барьлаа.



2.4.2. Гадаад улс орнуудын болон олон улсын байгууллагын дэмжлэгээр төсөл хэрэгжүүлж, сургалтын үйл ажиллагааг сайжруулна.

Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /TIKA/-ийн буцалтгүй тусламжаар **43,484.731** төгрөгийн тоног төхөөрөмжийн төслийг амжилттай хэрэгжүүлж, сургалтын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулан ажиллаж байна.



2.4.3. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослоос хамгаалах зорилгоор холбогдох мэргэжлийн хүмүүсээр сургалт зохион байгуулна.


❖ “Хүүхэд ямар нэгэн болзошгүй аюулаас өөрийгөө хамгаалах, цахим тоглоомоос урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт

Нийслэлийн Цагдаагийн Газрын Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн Хошууч Д.Оюун, А.Оюун-Эрдэнэ нар “Хүүхэд ямар нэгэн болзошгүй аюулаас өөрийгөө хамгаалах, цахим тоглоомоос урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад төвийн уран зураг, сүрлэн сүлжмэл, сүрлэн наамал, хүүхэлдэй бэлэг дурсгал, нисэх загвар, авто загвар, уран бичлэгийн дугуйлангийн 123 хүүхэд хамрагдлаа



Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Эрүүл мэндийн арга зүйч Ж.Дэлгэрсайхан, Нийгмийн ажилтан Б.Энхцэцэг нар 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр төвийн дугуйлангийн сурагчдад дараах сургалтыг зохион байгуулж, гарын авлага тараалаа. Үүнд:

- Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тухай
- Эрүүл зөв хооллолт, усаа зохистой хэрэглэцгээ



Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны “Сайн наран” өрхийн эрүүл мэндийн төв Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн дугуйлангийн сурагчдад өртөөлчилсөн сургалтыг зохион байгууллаа. Тус өртөөлчилсөн сургалт нь “Сүрьеэ, Сэтгэц, Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны тухай зөвлөгөө” зэрэг сэдвийн хүрээнд явагдлаа.



❖ “Тарваган тахал өвчнөөс урьдчлан сэргийлэх” сэдэвт сургалт

Төвийн эрүүл мэндийн арга зүйч Ж.Дэлгэрсайхан төвийн дугуйлангийн сурагчдад “Тарваган тахал өвчнөөс урьдчлан сэргийлэх” сэдэвт сургалт сургалтыг зохион байгуулж, 284 сурагчдыг хамрууллаа.



“2.5. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна.” заалтын хүрээнд:

2.5.1. Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаанд багш, сурагчдыг идэвхтэй хамруулна.

❖ “МОНГОЛ ХЯТАД НӨХӨРЛӨЛ” уран зургийн уралдаан

Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад Суугаа Элчин Сайдын Яам, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд “Монгол Хятад нөхөрлөл” уран зургийн уралдааныг Уран зургийн дугуйлангийн сурагч Б.Амирлан шилдгээр шалгарч БНХАУ-ын Шанхай хотын Олон улсын хүүхдийн арга хэмжээнд Монгол Улсаа төлөөлж амжилттай оролцлоо.



❖ “БИДНИЙ НАЙРАМДАЛ” Олон улсын хүүхдийн гар урлал, уран зургийн уралдаан

Монгол улсаас БНХАУ-ын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газар, Өвөр Монгол дахь Монгол иргэдийн нийгэмлэг, ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын хэвлэл мэдээллийн алба, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан “Бидний найрамдал” сэдэвт гар урлал, уран зургийн уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдаанд 1150 хүүхэд бүтээлээрээ оролцсоноос Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 6 хүүхэд, 1 багш шагналт байранд шалгарлаа.




❖ МИНИЙ АМЬДРАЛ ЭНД” Азийн хүүхдийн уран зургийн үзэсгэлэн

2018-2019 оны ээлжит уралдааны шилдэг 24 хүүхдийн бүтээлийн үзэсгэлэнг Монгол улсад анх удаа зохион байгуулж, Монголын хүүхдийн урлан бүтээх, “Байгаль, соёлын өвийг хамгаалах сан”, Юнескогийн батламжит ТББ хамтран “МИНИЙ АМЬДРАЛ ЭНД” Азийн хүүхдийн уран зургийн үзэсгэлэнг амжилттай зохион байгууллаа. 2017-2018 оны “Мицубиши Азийн хүүхдийн Энikki фестиваль”-д 24 орны 65,567 хүүхэд оролцсон бөгөөд Монгол улсаас 8 хүүхэд Гранпри болон тусгай байр, Япон улсын нэрэмжит шагналуудыг хүртлээ.



❖ “NORT ART” олон улсын уралдаан, үзэсгэлэн

Герман Улсаас зохион байгуулсан “NORT ART -2019” 21 дэх удаагийн Олон Улсын Дүрслэх урлагийн наадамд Монголын Хүүхдийн урлан Бүтээх төвийн уран баримлын багш Т.Даваасамбуу Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцлоо. Тус уралдаанд 102 орны 3000 уран бүтээлч өрсөлдсөнөөс шилдэг 200-д шалгарлаа.



❖ Моа дүрслэх урлагийн гар зургийн уралдаанд Анхан шатны дугуйлангийн сурагч Ч.Мишээл “Байгаль” зургаараа амжилттай оролцож шилдэг 10-т шалгарлаа.

2.5.2. Төвийн багш нарын “УРЛАГ БА УРЛАХУЙ” шилдэг уран бүтээлийн үзэсгэлэн зохион байгуулна.

❖ “УРЛАГ БА УРЛАХУЙ” шилдэг уран бүтээлийн үзэсгэлэн

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн багш нарын хамтарсан “УРЛАГ БА УРЛАХУЙ” уран бүтээлийн үзэсгэлэн 9 дахь жилдээ “Орд” арт галерейд амжилттай зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэнд төвийн 24 багшийн авьяас чадвар, ур ухаанаа уралдуулсан шилдэг 90 гаруй бүтээл оролцож, шилдэг 4 багшийг шагналаа.

Уралдааны шүүгчээр Монголын Урчуудын Эвлэлийн хороны Ерөнхийлөгч Б.Төмөрбаатар, Нийслэлийн Боловсролын Газрын мэргэжилтэн Г.Амарсанаа, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирал Д.Уранбилэг нар ажиллаа.



3.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

3.2.1. “3.1 Багшийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулна

❖ “ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ХҮСЭЛ МӨРӨӨДӨЛ РҮҮ НЬ ЧИГЛҮҮЛЖ, ХЭРХЭН УРАН БҮТЭЭЛЧ БОЛГОХ” сэдэвт сургалт

Соёл Урлагийн Их сургуулийн Дүрслэх урлагийн сургуулийн багш Доктор, Дэд профессор, МУЭ-ийн шагналт зураач, Уран барималч С.Бадрал “Хүүхэд залуучуудыг хүсэл мөрөөдөл рүү нь чиглүүлж, хэрхэн уран бүтээлч болгох” тухай сэдэвт сургалтыг төвийн багш, сурагчид болон Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн багш сурагч нарт зориулан “Орд” галерейд хийлээ.



❖ “ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГААС” сэдэвт сургалт

Урлаг судлаач, Монголын Урчуудын Эвлэлийн Хорооны шагналт зураач О.Сосор” төвийн багш, сурагчид, Нийслэлийн Ерөнхий боловсролын багш, сурагчдад “Орчин үеийн чиг хандлагаас” сэдэвт сургалт хийлээ.



“3.2. Төвийн багш, албан хаагчдын компьютер, гадаад хэлний мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор сургалтад хамруулна.

- ❖ Хамтын ажиллагааны хүрээнд “King Sejonghakdang” институтэд төвийн 3 албан хаагчийг үнэ төлбөргүй солонгос хэлний сургалтад хамруулж байна.

“3.3 Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн талаарх ойлголт болон шинээр гарсан хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулна.

- ❖ **“Хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг, гэр бүлийн хүчиэрхийлэл, жендер, зөрчлийн тухай хууль” сургалт**

Сүхбаатар Дүүргийн Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газрын мэргэжилтэн Б.Алтантүлхүүр, СБД-ийн 6-р хорооны Нийгмийн ажилтан н.Отгонзул нар төвийн багш албан хаагчдад “Хүүхэд Хамгаалал, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг, Жендерийн тухай, зөрчлийн тухай хуулийн талаар сургалт зохион байгуулж, төвийн багш албан хаагчид эрх зүйн мэдлэгээ дээшлүүлээ.



- ❖ **“Шинээр гарсан хууль тогтоомжийн” тухай сургалт**

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Дотоод хяналт, хуулийн зөвлөх Б.Лхамсүрэн шинээр гарсан хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгөх, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төвийн багш, албан хаагчдад шинээр гарсан хууль тогтоомжийн тухай сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад төвийн 40 багш, албан хаагч хамрагдав.



“3.4 Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд болон бусад мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулна.

- ❖ **“СТРЕССГҮЙ АЖ ТӨРӨХ, ХАМТ ОЛНЫ ЭВ НЭГДЭЛ” сэдэвт лекц**

Сэтгэл судлаач С.Отгонбаяр төвийн багш, албан хаагчдад зориулан “Стрессгүй аж төрөх, хамт олны эв нэгдэл” сэдэвт лекцийг уншиж танилцууллаа. Тус лекцийн зорилго ажлын байран дээр хамт олны эв нэгдлийг бий болгох, бусдыг зөвөөр танин мэдэх, хүндлэх, уучлах сэтгэлийг бий болгоход оршссон үр дүнтэй ярилцага боллоо.



❖ “БАГИЙН АЖИЛЛАГАА” сургалт

Хамт олны харилцаа хандлага, бие биенээ хүндэтгэх, хувь хүний соёл, аз жаргалын талаар “БАГИЙН АЖИЛЛАГАА” сургалтыг зохион байгууллаа.



3.4 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

3.4.1 “5.1 Багш, албан хаагчид, сурагчдын нийгмийн асуудалд анхаарч эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

- ❖ Хамтын ажиллагааны хүрээнд Төрийн Тусгай Албан Хаагчдын нэгдсэн эмнэлэгт төвийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.
- ❖ , Төвийн Эрүүл мэндийн арга зүйч Ж.Дэлгэрсайхан төвийн багш албан хаагчдаас “Бие бялдарын” сорил авж, багш албан хаагчид 100% хамрагдлаа.

5.2 Бүжгийн сургалт, спорт өдөрлөг, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол зохион байгуулж, бие бялдар эрүүл мэндийг дэмжинэ.

- ❖ Төвийн нийт багш албан хаагчдын эрүүл мэнд, дасгал хөдөлгөөнийг сайжруулах зорилгоор багш, албан хаагчдад “Венийн Вальс” бүжгийн хичээлийг 2 сарын турш зохион байгууллаа.



- ❖ “Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлыг арилгах зорилгоор өглөө бүр тогтмол гимнастик хийж байна.



5.3 Ажлын байрны болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон цаашдын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгана.

Төвийн багш албан хаагчдаас ерөнхий 8 асуулгаас бүрдсэн ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг авлаа. Судалгаанд нийт 58 багш, албан хаагч оролцсоноос, ажлын байрны сэтгэл ханамж 90% буюу хангалуун байна.

Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн суралцагч хүүхэд багачууд, эцэг эхээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Тус судалгаанд нийт 1552 хүн хамрагдаж, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг SPSS программ дээр боловсруулан дүгнэлт гаргав. Дүгнэлтээр эцэг эх асран хамгаалагчдын хувьд тус төвийн явуулж буй үйл ажиллагаа хүүхэд багачууд олон нийтэд нээлттэй байдаг, сургалтын арга барил хүүхэд багачуудад таалагддаг гэж үнэлэгдэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 85,6% буюу В үнэлгээтэй байна

Тус судалгаан дээр үндэслэн цаашид хүүхдүүдийн сургалтын орчин, зарим анги танхимын ширээ сандлын хүрэлцээ, эрүүл аюулгүй байдал, тохижилтод анхааран ажиллана.

5.4 Төрийн албан хаагчдад зориулан Авлигын эсрэг боловсрол олгох сургалт зохион байгуулж, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллана.

Авлигатай тэмцэх газрын газрын Урьдчилан сэргийлэх, Соён гэгээрүүлэх хэлтсээс 2019 онд иргэн, төрийн албан хаагч, иргэний нийгмийн байгууллагад авилгын эсрэг сургалтад төвийн хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хамрагдлаа. Тус сургалтын хүрээнд төвийн нийт багш албан хаагчдад хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан сургалт зохион байгууллаа.

3.5. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ХАРИУТАЙ БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ:

3.5.1 “6.1 Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглаж, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллана.

- ❖ Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ub.gov.mn цахим хуудас

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн 10 захиргааны албан хаагч www.edoc.ulaanbaatar.mn программыг ашиглаж, түүний хэрэгжилтэд албан хэрэг хөтлөлтийн ажилтан хяналт тавин ажиллаж байна.

2019 оны байдлаар:

	Албан бичиг	Нийт тоо	Үүнээс:	Шийдвэрлэлт
1	Ирсэн бичиг	189	59 хариутай	99,32%
			130 хариугүй	
2	Явсан бичиг	61	61 хариугүй	100%

“6.2 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглана.

Төвийн нийт 54 багш, албан хаагчид www.erp.ulaanbaatar.mn программыг ашиглаж, түүний хэрэгжилтэд хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хяналт тавин ажиллаж байна.

“6.3 Байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулж, цахим нөхөн бүрдүүлэлтийг тогтмол хийнэ.

Захирлын А, Б тушаалуудыг нөхөн бүрдүүлэлтээр цахим хуудаст оруулж, байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

“6.4 Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг байгуулж, үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллана.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг томилон, төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж үүрэг даалгаврын дагуу биелэлтийг ханган ажиллаж байна. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хамрагдаж 88,6 %-тай В үнэлэгээ авсан.

3.6. “ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХӨГЖЛИЙН ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД:

3.6.1 “7.1 Багш, сурагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай харилцан туршлага солилцоно.

❖ “ХУН19” хүүхдийн урлагийн наадам

ХБНГУ-ын Урлагийн Боловсролын сургуультай хамтран "Хүүхдийн Урлагийн наадам 2019" ийг зохион байгууллаа.

Тус өдөрлөгт Герман улсын Берлин хотын 5 уран бүтээлч багш хүрэлцэн ирж Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын болон төвийн хүүхэд багачуудад сургалтуудыг зохион байгуулав.

Тус сургалтад төвийн 300 гаруй Нийслэлийн ЕБС-ийн нийтдээ 700 хүүхэд хамрагдлаа. Сургалтад хамрагдсан сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж олны хүртээл болгов.

Үзэсгэлэнгийн нээлтэд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирал Д.Уранбилэг, Төслийн санаачлагч ХБНГУ дахь Монгол Улсын Соёлын Элч О.Оюунтуяа, Jugendkunstschule JKS CW Lutz Lienke, Karin Fortriede- Lange нар оролцож үг хэллээ.



❖ “ОЛОН УЛСЫН СУРАГЧ СОЛИЛЦОО-2019”

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас жил бүр зохион байгуулдаг “Олон Улсын Сурагч Солилцоо-2019” хөтөлбөрийн арга хэмжээнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв 3 дахь жилдээ амжилттай хамтран оролцлоо.

Тус хөтөлбөрийн хүрээнд Япон улсын Мияконожо хот, ОХУ-ын Эрхүү хот, БНХАУ-ын Хөх хотын 37 сурагч Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвөөр зочилж, төвийн үйл ажиллагаатай танилцлаа.

Хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад Монголын уран бичлэгийн дугуйлангийн сурагчид үндэсний эх бичиг Монгол уран бичлэг, сүрлэн сүлжмэлийн сургалтыг зохион байгууллаа.



- ❖ БНХАУ-ын Эрээн хотын Хүүхэд Залуучуудын төвийн 35 багш, сурагч Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвөөр зочилж, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвтэй танилцах аялал хийлээ.



- ❖ ОХУ-ын Эрхүү хотын Тусгай хэрэгцээт боловсролын 20-р сургуулийн багш нар Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвөөр зочилж, Монгол улс, Эрхүү хотын хүүхдүүдийн үзэсгэлэн уралдаан зохион байгуулахаар хэлэлцлээ.



- ❖ “Хүрээ Тулга” дунд сургуулийн 17 сурагч, багш эцэг эхийн хамт Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвтэй танилцаж, авто загварын дугуйлангийн онцлог, ач холбогдлын талаар сургалт явууллаа.



- ❖ Сэлэнгэ аймгийн 4-р сургуулийн 34 сурагч, 3 багш мэргэжил сонголт аяны хүрээнд Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвөөр зочилж, Монгол уран бичлэгийн сургалтыг зохион байгууллаа.



“7.2 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төвийн үйл ажиллагааг сурталчилж, хүүхэд багачуудад дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн цуврал хичээл бэлтгэж нийтийн хүртээл болгоно.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, олон нийтийн арга хэмжээг тогтмол хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчлан, олон нийтийн хүртээл болгож байна. Тухайлбал, MYONPT, Монгол HD, Eagle TV, TV9, SBN, LIKE TV, STAR TV, GTV, VTV, ETV, SCN TV, Үндэсний шуудан, Нийслэл сайт, Read.mn, Монголын радио, Монголын мэдээ сонин, Өдрийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна.

Теле хичээл

- 2019 онд -18

Ярилцлага, хэлэлцүүлэг

- 2019 онд - 6

Үзэсгэлэн уралдаан

- 2019 онд -40

- ❖ Үзэсгэлэн, уралдаан, олон нийтийн арга хэмжээнд ирсэн телевизүүдийн нэгдсэн товъёог:

ЗОХИОГДСОН ҮЗЭСГЭЛЭН		САР ӨДӨР	МЭДЭЭЛЭЛ АВСАН ТЕЛЕВИЗҮҮД
1	“Монголын сайхан бичигтэн 2018” улсын уралдааны шилдэг бүтээлийн үзэсгэлэн	01/07	STAR ТВ, ТМ ТВ, МОНЦАМЭ, EAGLE ТВ, UBS ТВ, MNS ТВ
2	“Өв Соёл” Монгол зургийн үзэсгэлэн	02/12	MNB ТВ
3	“Монгол-Хятад нөхөрлөл” уран зжргийн үзэсгэлэн	02/13	MNB ТВ
4	“ART & CRAFT-9” багш нарын уран бүтээлийн уралдаан үзэсгэлэн	02/18	МОНЦАМЭ ТҮ9 ТВ, ТМ ТВ, ММ агентлаг, Монголын мэдээ сонин, Ардчилал таймс сонин
5	“ТУСГААР ТОГТНОЛЫН ҮНЭ ЦЭН” уран зураг, гар урлал, уран бичлэг, технологийн анхдугаар наадам	03/01	ETV, ТМ ТВ МОНЦАМЭ шууд, MNB ТВ
6	“Уран баримал- 2019” үзэсгэлэн	03/13	MNB. ТҮ9 ETV ТВ
7	“НЭГ ЕРТӨНЦ” яруу найраг, Монгол уран бичлэгийн үзэсгэлэн	03/21	ТҮ9 ТВ, МОНЦАМЭ
8	“Дээрэлхэл миний бодлоор” дунд сургуулийн сурагчдын гар зургийн үзэсгэлэн	03/27	101 FM
9	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн дүрслэх урлаг дизайн технологийн багш нарын ШИНЭЛЭГ САНАА- 2019” уран бүтээлийн наадам үзэсгэлэн	04/10	STAR ТВ, ТМ ТВ, МОНЦАМЭ, өнөөдөр сонин
10	“Гоо-Ивээл” хувцас загварын уралдаан үзэсгэлэн	04/19	STAR ТВ, MNB ТВ, ТВ9 ТВ, EAGLE ТВ, Зууны мэдээ сонин
11	“БАЯРЛАЛАА ТУРК ОРОН” Хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн	04/29	STAR ТВ, MNB ТВ, TV9 ТВ, Зиндаа.мн. ТМ ТВ, МҮОНТВ
12	“МИНИЙ АМЬДРАЛ ЭНД” Азийн хүүхдийн зургийн үзэсгэлэн	05/07	STAR ТВ, ММ Зиндаа.мн. ТМ, МҮОНТҮ шууд, Монгол ТВ,
13	Нийслэлийн 380 жилийн ойн “УРЛАХУЙН ЕРТӨНЦ” тайлан үзэсгэлэн	05/11	Монголын үндэсний радио 106.0 FM
14	“Маргад-Эрдэнэ Миний Эрдэнэ” аянд нэгдэн, хүмүүнлэгийн үйлсийн төлөө “MERAKI” үзэсгэлэн	05/30	MNB ТҮ, зариг, мн,
15	Халх голын 80 жилийн ойн хүрээнд 2 орны хүүхдүүдийн “Бид үл мартана” үзэсгэлэн	09/03	MNB. ТҮ9 ETV ТВ
16	Торгоны зам олон улсын загварын 7 хоног шилдэг бүтээлийн үзэсгэлэн	09/16	MNB. ТҮ9 ETV ТВ
17	“Үүлсийн гүнд” үзэсгэлэн	09/17	Монголын үндэсний радио 106.0 FM
18	“ХУН19” үзэсгэлэн	10/14	ETV, ТМ ТВ МОНЦАМЭ шууд, MNB ТВ
19	Туркийн элчин сайд Мехиттин Ахмет Язел түүний эхнэрийн дэмжлэгээр зохион	11/04	MNB. ТҮ9 ETV ТВ

	байгуулсан Уран зургийн үзэсгэлэн		
20	Байгал говь үзэсгэлэн	11/07	MNB, TY9 ETV TB
21	Мөнх тэнгэрийн бичиг	11/25	ETV, TM TB МОНЦАМЭ шууд, MNB TB
22	Монгол Энэтхэг улсын хамтарсан Өнгөрсөн – Одоо - Ирээдүй	12/16	ETV, TM TB МОНЦАМЭ шууд, MNB TB

❖ Телевиз, радио, хэвлэл мэдээллийн байгууллагад өгсөн ярилцлага, мэдээ, нэвтрүүлгийн нэгдсэн товъёог

/Хүснэгтээр/

	ТЕЛЕВИЗИЙН НЭР	САР ӨДӨР	ЯМАР СЭДВЭЭР	МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН НЭР
1	TB9 өглөөний хөтөлбөр	01/10	Цаас скочны гол, бөглөө ашиглаж утсан хүүхэлдэй хийх, даавууны өөдөс ашиглан зөөлөн тоглоом хийх талаар	Монгол хувцас загварын багш Г.Гэрэлмаа
2	TB9 өглөөний хөтөлбөр	01/14	“Төмөр утастай хатуу туузыг том шүр, наадаг шүрэн чимэглэл ашиглан хийх талаар мөн гэрлийн шилээр шинэ жилийн тоглоом хийх талаар	Хүүхэлдэй бэлэг дурсгалын багш Б.Булгантуяа
3	TB9 өглөөний хөтөлбөр	01/18	Хайч, цаас ашиглан “Тэгш хэм Өлзий хээ хайчлах, “Ваартай цэцэг” кофегоор зурах талаар	Уран хайчилбарын багш Т.Ганхуяг
4	TB9 өглөөний хөтөлбөр	01/20	“Зураг зурах аргачлал”- ын талаар	Монгол уран зургийн багш Н.Мөнхтуул
5	ETV телевиз	01/24	“Сайхан хүмүүс” хөрөг нэвтрүүлгээр	Захирал Д.Уранбилэг
6	TB9 өглөөний хөтөлбөр	02/25	“Хүүхэлдэй хийх” аргачлалын талаар	Хүүхэлдэй бэлэг дурсгалын багш Ж.Сарантуяа
7	Үндэсний шуудан сонин	02/26	“Хичээлээс гадуур чөлөөт цагаараа дугуйланд явснаар юу сурч мэдэж авсан талаар” ярилцлага	Анхан шатны дугуйлангийн сурагч Т.Цогзолмаа, Хүүхэлдэй бэлэг дурсгалын дугуйлангийн сурагч Б.Цэлмүүн
8	TB9 өглөөний хөтөлбөр	03/01	“Хүүхэлдэй, картон цаасаар зургийн жааз яаж хийх талаар	Хүүхэлдэй бэлэг дурсгалын багш Ж.Сарантуяа
9	TB9 өглөөний хөтөлбөр	03/13	“Ханын чимэглэл торго, тууз, цавуу, картон цаас ашиглан бүтээл хийх талаар	Хүүхэлдэй бэлэг дурсгалын багш А.Үржинханд

10	ТВ9 өглөөний хөтөлбөр	03/29	“Барималын шавар, гялгар материал, харандаа ашиглан хүүхэлдэй хийх талаар	Анхан шатны багш Ц.Дуламсүрэн
11	ТВ9 өглөөний хөтөлбөр	04/13	“Зургийн цомог цаасан хайрцаг, картон цаас, өнгийн цаас ашиглан жааз” хийх талаар	Анхан шатны багш Д.Нямгэрэл
12	ТВ9 өглөөний хөтөлбөр	05/09	“Баримлын шавраар төрөл бүрийн амьтан” хийх талаар	Анхан шатны уран баримлын багш Б.Ичинхорлоо
13	EAGLE NEWS HD телевиз	05/30	“Хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл санааны хөгжил өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг” хэлэлцүүлэг	Дотоод хяналт, Хуулийн зөвлөх Б.Лхамсүрэн
14	Монгол HD телевиз	06/03	“Сүрлээр бүтээл хэрхэн” хийх талаар	Сүрлэн сүлжмэлийн багш Б.Нарантунгалаг

“7.3 Төвийн байнгын галерейг шинэчилж төрөлжүүлнэ.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв “Өв соёл” галерейг төвийн багш сурагчдын бүтээлүүдээр төрөлжүүлэн өөрсдийн хүчээр шинэчлэн засварлаж, Үндэсний өв уламжлалыг сурталчлан таниулж байна.



❖ Хүүхдийн галерей



3.7. НИЙСЛЭЛИЙН 380 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД :

3.7.1 “8.1 Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд төвийн багш, сурагчдын хамтарсан “УРЛАХУЙН ЕРТӨНЦ” тайлан үзэсгэлэнг зохион байгуулна.

Нийслэлийн 380 жилийн түүхт ойн баярыг тохиолдуулан Улаанбаатар хотын түүх соёлыг олон нийтэд сурталчлан таниулах, төвийн суралцагч хүүхдүүдийн авьяас чадвар, бүтээлч сэтгэхүйг хөхүүлэн дэмжих зорилгоор Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн сурагчдын “УРЛАХУЙН ЕРТӨНЦ” үзэсгэлэн, 2018-2019 оны хичээлийн жилийн хаалтын үйл ажиллагааг 2019 оны 05 дугаар сарын 11-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Тус үзэсгэлэнд төвийн шилдэг сурагчид уран зураг, гар урлал, технологийн 220 бүтээлээр оролцлоо.



❖ **“ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР УДИРДАМЖ – ЭКО- ЭРҮҮЛ ХООЛНЫ ӨДӨРЛӨГ”**

“Эко – Эрүүл хоол” -ны өдөрлөг зохион байгууллаа.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, дугуйлангийн талаарх мэдээ мэдээллийг төвийн вебсайт, Фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллана.

❖ Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй байлгах хүрээнд:

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй ажиллуулж, мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж байна.





❖ Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлын хүрээнд:

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв 2019 онд нийт 784,979,161.00 төгрөгийн орлогоос 774,512,646.00 төгрөгийн зарцуулалт хийгдэж 10,466,515.00 төгрөгийн үлдэгдэлтэй өглөг авлагагүй ажиллаа.

[illegible]

4.2. Хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллана.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн хүний нөөцийн ил тод байдлыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй ажиллуулж, мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж байна



4.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.

- ❖ Хуулиар тогтоосон хугацаанд <https://shilendans.gov.mn/org/4315> сайтад мэдээллийг тогтмол байршуулж байна.
- ❖ <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

❖ “ИХ ХОТЫН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ 90 МИНУТ”

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/301 тоот захирамжийн дагуу манай хамт олон 52 хүний бүрэлдэхүүнтэйгээр Дунд голын ойр орчим болон Алтай хотхоны Космо дэлгүүрээс баруун тийш Төрийн банк хүртэлх 420 метр талбайг цэвэрлэн, 30 шуудай хог түүлээ. Мөн Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, явган хүний замыг цэвэрлэж, хаврын их цэвэрлэгээг хийлээ.



“ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬ” сургалт

Нийслэлийн Засаг Даргын “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд оролцуулах” тухай 2019 оны А/243 тоот захирамжийн дагуу төвийн албан хаагчид гамшгаас хамгаалах сургалтыг төвийн анхан шатны анги болон төвийн гадна цугларах талбайд 53 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа. Тус сургалтыг 4 чиглэлийн хүрээнд зохион байгууллаа. Үүнд:

1. Гамшгийн бэлэн байдлыг хангах шаардлага үндэслэл, газар хөдлөлтийн аюулын өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгөх
2. 3 дугаар сард Нийслэл даяар явагдах бэлэн байдлын сургуулийн зорилго ач холбогдол тус төвийн бие бүрэлдэхүүний оролцооны талаар
3. Тус төвийн мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдлын томилгоо, тодотголыг уншиж танилцуулах
4. Хүн нэг бүрийн бэлэн байдлын үүргэвчинд байвал зохих 15 зүйлийн талаар нэг бүрчлэн тайлбар хийж , танилцуулан тараах материал бэлтгэн хүн нэг бүрд өгөх зэрэг сургалтуудыг багш албан хаагчдад зохион байгууллаа.



❖ “ДИЖИТАЛ АРТ” үзэсгэлэн

Монгол-Солонгос хэл соёлын солилцооны төв , Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв хамтран хөгжлийн бэрхшээлтэй уран бүтээлчдийн "Дижитал арт" үзэсгэлэнг “Орд” арт галерейд амжилттай зохион байгууллаа.



❖ “Архигүй зөв амьдарцгаая” ярилцлага, сургалт

Дүүргийн Засаг Даргын 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Аян зохион байгуулах тухай А/61 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Архигүй зөв амьдарцгаая” аны хүрээнд АА нийгэмлэгтэй хамтран Монголын хүүхдийн Урлан Бүтээх төвд тус ярилцлага, сургалтыг зохион байгууллаа. “Архигүй зөв амьдарцгаая” ярилцлага, сургалт 400 гаруй хүн хамрагдлаа.



Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан дараах байдлаар илэрхийлвэл:

	Шалгуур үзүүлэлт		2018	2019 он
1	Төвийн дугуйлангийн хүүхдийн тоо		2005	2079
2	Салбар дугуйлангийн тоо		6	13
3	Салбар дугуйланд суралцагч хүүхдийн тоо		200	329
4	Үзэсгэлэн, уралдаан		11	21
5	Сургалт, зөвлөгөөн	Сурагчдад	18	18
		Багш, албан хаагч	12	13
6	Теле хичээл		8	18
7	Ярилцлага, нэвтрүүлэг		2	6
8	Төсөл, хөтөлбөр		0	3
9	Өргөдөл, гомдол, хүсэлт		14	14
10	Өр, авлага		0	0

ДҮГНЭЛТ

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв нь 2018-2019 оны хичээлийн жилд “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” эрхэм зорилго дэвшүүлэн Монгол уран зураг, Монгол хувцас дизайны ангийг шинээр нээж 17 төрлийн 24 дугуйланд нийт 2079 хүүхдийг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр үнэ төлбөргүй сурган хөгжүүлж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган 5 бүлгээр 33 ажил, үйл ажиллагаа төлөвлөн биелэлтийг бүрэн хангаж ажиллаа.

Байгууллагын батлагдсан төсвийг зүй зохистой зарцуулан, төсвийн хэмнэлт гаргаж өр төлбөргүй ажиллаа.

2018-2019 оны хичээлийн жилд “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” эрхэм зорилгын хүрээнд өөрсдийн хүчээр шинэчлэн засварласан Үндэсний өв уламжлалыг сурталчлан таниулах зорилго бүхий “Өв соёл” галерей, Хүүхдийн галерей, Номын сан зэргийг шинээр нээж, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /TIKA/-ийн буцалтгүй тусламжаар Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн төслийг амжилттай хэрэгжүүллээ.

“Дүрслэх урлаг ба гар урлал” анхан, дунд шатны сурах бичгийг шинээр эмхлэн хэвлүүлж урлан бүтээх хүсэл эрмэлзлэл дүүрэн дугуйлангийн сурагчиддаа бэлэг барьлаа. Мөн авьяаслаг уран бүтээлч хүүхэд багачуудыг нийтэд сурталчлан таниулах зорилгоор Олон улсын байгууллагууд, Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай идэвхтэй хамтран олон талт арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН _____ /Л.АТАР/

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ _____ /Д.УРАНБИЛЭГ/